

МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ-ЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
ХЯНАЖ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Хүний нөөцийн хөгжлийн стратеги түүний хэрэгжилтийг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр үнэлэн үр дүнд хяналт тавьж ажиллана.Үүнд:

НЭГ: Төрийн албаны оновчтой томилгоо хийсний үндсэн дээр хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал

ХОЁР: Нийт албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээг хангах, сургалтын тогтолцоог бий болгосны үндсэн дээр хүнээ хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал

ГУРАВ: Удирдах ажилтнууд нь хүний нөөцийн удирдлагад суралцаж “Хүнтэй ажиллах, зөв удирдах” зан үйлд тасралтгүй суралцах боломжоор хангах удирдлагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал

ДӨРӨВ: Албан хаагчдын манлайллыг хөгжүүлэх, карьер өсгөх, оновчтой арга замыг хэрэгжүүлсэн байдал

ТАВ: Байгууллагын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн байдал

ЗУРГАА: Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал